ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ**

**ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 30 өдөр Дугаар А/59 Улаанбаатар хот

Ажлын төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.1 дэх заалт, Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны Авлигын эсрэг үйл ажиллагааны 2020 оны ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, биелэлтэд хяналт тавьж, ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Г.Одбаатар/-т даалгасугай.

ДАРГА Ц.ШАРАВЖАМЦ

000000285

Засгийн газрын тохируулагч агентлаг
Биеийн тамир, спортын улсын хорооны даргын
2020 оны 10 дугаар сарын 30-ний өдрийн
А/59 тоот тушаалын хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ-БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | № | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | | Хариуцах нэгж, мэргэжилтний нэр | Төсөв | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | | | |
| **Урьдчилан сэргийлэх , соён гэгээрүүлэх үйл ажиллагаа** | | | | | | | |
| Нэг. Авлигын эсрэг хууль тогтоомж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | | | | | | | |
| 1. | Биеийн тамир, спортын улсын хорооны "Авлигын эсрэг үйл ажиллагааны 2020 оны ажлын төлөвлөгө"-г батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах | | Газрын даргын тушаалаар батлуулж, хэрэгжилтийг хангаж, арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. | IV улирал | ТЗУГ | - | Төлөвлөгөө чанартай , үр дүнтэй хууль тогтоомжын хүрээнд хэрэгжүүлж, тодорхой үр дүнтэй үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэн ил тод байдлыг хангаж ажилласан байна. |
| 2. | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ хүрээнд гаргаж ирүүлсэн шийдвэр, зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх арга хэмжээг авч ажиллана. | | Авлигатай тэмцэх газраас ажил зохион байгуулах, зөрчил арилгуулах, хариуцлага тооцуулах зэрэг арга хэмжээний талаар ирүүлсэн албан бичгүүдийг хүлээн авч,шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | Тухай бүр | ТЗУГ | - | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ хүрээнд гаргаж ирүүлсэн шийдвэр, зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж, биелэлтийг хүргүүлсэн байна. |

| Байгууллагын ил тод байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хоёр. Хүний нөөц | | | | | | | |
| 4. | Биеийн тамир, спортын улсын хорооны хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтэд мэдээлэл авах боломж, нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллана. | | БТСУХ-н даргын бүрэн эхийн хүрээнд томилогддог ажлын байрны сул орон тооны болон сонгон шалгаруулалтын зар, журам түүнтэй холбогдолтой мэдээ, мэдээллийг цахим хуудсанд байршуулна. Зарим ажлын байрны тодорхойлолтыг шаардлагатай тохиолдолд өөрчлөлт хийж, Сонгон шалгаруулалтад хүссэн иргэн чөлөөтэй өрсөлдөх боломжыг бүрдүүлж, холбогдох мэдээллийг цахим хуудсанд тухай бүр байршуулсан байна. | Тухай бүр | ТЗУСХ | - | . Байгууллагын хүний нөөцийн ил тод байдлыг хангагдсан, олон нийтэд мэдээлэл авах боломж, нөхцлийг бүрдсэн байна. |
| 5. | Нийтийн албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх, | | Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулж, бүртгэл хөтлөх | Тухай бүр | ТЗУСХ Н.Батсүх | - | Нийтийн албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулж, бүртгэл хөтөлсөн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Гурав. Санхүү, эдийн засаг | | | | | | | |
| 6. | Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтын зарцуулалтыг ил тод нээлттэй болгож нийтэд мэдээлэх. | | Төсвийн орлого, зарлага болон Худалдан авах ажиллагаа,тухайн жилийн төсөв, өмнөх жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, төсөвт орсон өөрчлөлт, дараа жилийн төсвийн төсөл зэргийг цахим хуудсанд байршуулна. | Тухай бүр | СХОХ | - | Шилэн дансны хууль болон холбогдох журмын дагуу байгууллагын төсөв, санхүү, аудитын тайлантай холбоотой мэдээ, мэдээллийг цахим хуудсанд бүрэн байршуулж ажилласан байна. |
| **Хяналт, шинжилгээ, үнэлгээ** | | | | | | | |
| Дөрөв. Хяналт шинжилгээ, үнэлгээ | | | | | | | |
| 7. | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгэх<br>Төрийн байгууллага түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх | | Газар, хэлтэст төлөвлөгөөний дагуу хяналт , шалгалтыг хууль тогтоомжын хүрээнд нийцүүлж хийх<br>Хяналт шинжилгээ үнэлгээ, ,шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчлийг холбогдох байгууллага , албан тушаалтанд шилжүүлэх, | Тухай бүр | ХШҮДАХ | - | Төлөвлөгөөнд тусгагдсан хяналт, шалгалтыг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, хяналт, шалгалтын дүнг, өгсөн зөвлөгөө, зөвлөмж, авах арга хэмжээ түүний талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байна. |

---oOo---